

## ХЯТАД УЛСЫН ГИРИН МУЖИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ЗҮҮН ХОЙД АЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Бинь Жэн\**

### **Нэг. Жилинь мужийн эдийн засаг Хятадын Зүүн хойд нутгийн эдийн засаг дахь байр суурь ба үүрэг**

Жилинь муж нь Хятадын Зүүн хойд бүс нутагт хойгуураа Хармөрөн, өмнүүрээ Ляонин, баруугаараа Өвөр Монгол, зүүн, зүүн өмнүүрээ ОХУ, Хойд Солонгостой хил залгаа оршдог. Нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 182.4 мянган км<sup>2</sup>, хүн амын тоо 26 сая 900 мянга. Бүс нутгийн байршил далайд ойр, хилийн зурвасын нийт урт 1447 км, Япон далайгаас 4 км зайтай байрладаг байна. Ойрын 20 жилд Хятадын эдийн засгийн хурдацтай хөгжлийн үрээр тус мужийн эдийн засаг хурдацтай хөгжиж байна. ДНБ-ий үйлдвэрлэлийн хэмжээ 1980 оны 9.86 тэрбум юаниас 2002 онд 220 тэрбум юань /ойролцоогоор 27 тэрбум ам.доллар/ болж 20 гаруй дахин өссөн байна. 2002 онд тус мужийн эдийн засгийн өсөлт 9.3%-д хүрсэн нь Хятаддаа 12-р байрт орж байна. Эдийн засгийн нийт хэмжээгээрээ улсдаа 19 дүгээрт, нэг хүнд ногдох ДНБ-ий дунджаар 14 дүгээрт орж байгаа нь хөгжлийн чиг хандлага нааштай байгааг харуулж байна.

Жилинь мужийн эдийн засаг дараахи 4 онцлогтой:

1. Байгаль орчин, экологийн үлэмж таатай байдал. Жилинь мужийн зүүн хэсэгт орших Чанбайшан гэдэг уул, шигүү ой модтой, ус уул уурхайн нөөц, байгалийн баялаг арвинтай. Дунд хэсэгтээ Сун Ляо тал газрын хөрс шороо үржил шимтэй, зам тээвэр хялбар. Баруун талдаа Хорчин тал нутгийн хөрс шороо нь үржил шимтэй, өргөн уудам бэлчээрийн газар нутагтай. Уг газар экологийн хурцадмал байдалд хараахан хүрээгүй, хүн амын нягтрал хэвийн /2002 онд нэг км<sup>2</sup> газарт 50 хүн/ байна. 2001 онд Жилинь мужийн ойн хэмжээ 42.5%, тал нутгийн хэмжээ 25%-ийг эзэлж байгаа ба 1648 голтой. Энэ нь цаашид бүс нутгийн хөгжүүлэхэд тааламжтай нөхцөл юм.

2. Хятадын үр тарианы үйлдвэрлэлийн томоохон муж, тариалан, мал аж ахуйн үндэс бааз суурь сайн. Муж нь 4 сая га тариалангийн талбайтай нь газар нутгийн 21.1%-ийг эзэлдэг. Нэг хүнд оногдох тариалангийн талбайн хэмжээ 0.15 га ба дотоодын дундаж

---

\*Бинь Жэн - БНХАУ-ын Жилинь мужийн Нийгмийн ШУА-ийн захирал, доктор, профессор

төвшнээс дээгүүр байна. Мөн эрдэнэ шиш, төмс, хүнсний тосны гол үйлдвэрлэгч бүс нутаг юм. Үр тарианы үйлдвэрлэлийн хэмжээ 25 сая тн байна. Харин мал аж ахуйн үйлдвэрлэл мужийн хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлийн 43.3%-ийг эзлэж байна.

3. Тус муж нь шинэ Хятад улсын ууган аж үйлдвэрийн суурь газар юм. Өнгөрсөн зууны 50-иад оны үед, Хятад улс тус мужыг дотоодын гол чухал аж үйлдвэрийн бааз газар болгон бүтээн байгуулж, маш хурдацтайгаар машин, химийн аж үйлдвэрээр голлосон аж үйлдвэрийн чухал бааз газар болгосон юм. Одоогоор тус мужийн Чанчун хотын Хятадын нэгдүгээр машин үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ 470.000-д хүрсэн ба борлуулалтын орлого 70 тэрбум юаньд хүрээд байна. Энэ нь мужийн ДНБ-ий 1/3-ийг эзлэж байгаа бөгөөд тус муж зүүн хойд Хятад дахь машин аж үйлдвэрлэлийн төв болоод байна.

4. Хотжилт болон соёлын төвшин өндөр. 2002 онд хүн амын 50%-иас дээш хот, суурин газар амьдарч байна. Энэ нь Хятадын дундаж 37%-ийн төвшнөөс давуу юм. 10000 тутам хүн тутамд дээд боловсролтой хүний тоогоороо улсдаа 7-рт, шинжлэх ухаан, техникийн мэргэжилтэй хүний тоогоороо улсдаа 11-рт, эмнэлэгийн мэргэжилтэний тоогоороо улсдаа 9-т ордог нь дотоодын дундаж төвшингөөс өндөр байна.

Одоогоор Жилинь муж нь машин, нефть химийн аж үйлдвэр, цахилгаан хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, эм эмчилгээ гэх мэт 5 том аж үйлдвэрийн тулгуур салбартай. Жилинь муж нь аж үйлдвэрийн бүс, шинжлэх ухаан, соёл боловсролын бүс, экологийн бүс байгуулах хөгжлийн зорилт дэвшүүлэн тавьсан. Мужийн эдийн засаг хурдацтай, эрүүл, тогтонги хөгжиж байна. Дэлхийн эдийн засгийн даяаршлын энэ эрин үед Жилинь мужийн эдийн засаг ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагаанд гол зонхилох үүрэг гүйцэтгэж байна.

### **Хоёр. Жилинь мужийн эдийн засгийн хөгжил ЗХА-ийн эдийн засгийн хөгжилтэй харилцан уялдах харилцаа**

2001 онд Жилинь мужид гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж 3832, хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 11.29 тэрбум ам.доллар болоод байна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид БНСУ, Япон зэрэг ЗХА-ийн улсуудын хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжүүд 50-иас дээш хувийг эзэлж байна. 1980-2001 онд Жилинь мужийн экспорт, импортын нийт хэмжээ 33 тэрбум ам.долларт хүрсэн ба түүнээс экспорт 19.1 тэрбум ам.доллар, жилийн дундаж өсөлт 16%

болж байна. Харин импорт нь 13.9 тэрбум ам.доллар, жилийн дундаж өсөлт 19% болж 2001 оны байдлаар мужийн экспорт импортын нийт хэмжээ улсдаа 14-рт орж, өсөлтийн хурдаараа 4-рт орж байна. Гадаад худалдаа, хамтын ажиллагааны хувьд, ялангуяа ЗХА-ийн улс хоорондын гадаад худалдаа, хамтын ажиллагаа нь Гирин мужийн эдийн засгийн хурдацтай хөгжлийг үргэлжлүүлэн хөгжүүлэх хөдөлгөгч хүчин зүйлийн нэг болоод байна.

ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаанд Жилинь муж нь өөрийн гэсэн давуу тал онцлогтой юм. Үүнд:

1. Газар зүйн онцлог байршлаараа давуу. Муж нь зөвхөн зүүн хойд Хятадын дунд хэсэгт байрлахаас гадна мөн далайн эрэг орчмын мужуудтай хиллэдэг. Хилийн зурвасын нийт урт 1447 км, түүн дэх Хятад, Хойд Солонгосын хилийн зурвас 1206 км, Хятад Оросын хилийн зурвасын урт 232 км, нийтдээ төрөл бүрийн 15 боомт байдаг. 2001 онд мужийн хил худалдааны нийт хэмжээ 0.13 сая тэрбум ам.долларт хүрсэн байна. Жилинь мужийн Хунчунь хот нь Түмэн голын хажууд байрладаг нь Хятад, Хойд Солонгос, ОХУ зэрэг гурван улсын хилээр хиллэдэг газар буюу Түмэн голын хөгжлийн чухал гол газар зүйн байршлын төв болоод байна. Жилингийн Байчөн хотоос галт тэргээр хөдлөөд Улаан хотыг дайрч Дасинан уулыг өнгөрөөд Рашаан ууланд хүрэхэд ердөө 400 км хүрэхгүй газар байгаа ба энэ нь Монгол Улсад хүрч болно гэсэн үг. Иймээс Жилинь муж нь ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутагт дотооддоо Хэйлунзян / Хар мөрөн/, Ляонин-г Өвөр Монголтой, гадааддаа ОХУ, Хойд Солонгос, Өмнөд Солонгосыг Монгол Улстай холбож өгөж чадах юм.

2. Эдийн засгийн онцлог нь бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд давуу талтай. Жилинь муж машин аж үйлдвэрлэлээ 2007 он гэхэд 700.000 машин үйлдвэрлэх төвшинд хүргэх, 2010 онд 1 сая машин үйлдвэрлэхээр төлөвлөж, ирэх 20 жилийн дотор 50 сая машин үйлдвэрлэхээр төлөвлөөд байна. Иймд зөвхөн Хятадын машины үйлдвэр дан ганцаар хангалтгүй байна. Энэ нь Хятад, Япон улсыг машины үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллах өргөн цар хүрээтэй хэтийн төлөвийг нээж өгч байгаа юм. Хэрвээ Хятад, Япон, БНСУ гурван улс нь машины үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлбэл цаашид дэлхийн хэмжээний ЗХА-ийн машин үйлдвэрлэлийн хүрээг бий болгох боломжтой юм.

ОХУ, Алс Дорнодын улс Жилинь мужтай адил байгалийн баялаг арвинтай. Эм эмчилгээний арвин баялагтай уудам нутаг бүхий ОХУ, Монгол нь тус мужаас илүү байгалийн арвин нөөцтэй. Энэ бүс нутгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв ирээдүйтэй юм.

3. Аж үйлдвэрлэлийн өөрчлөлт нь ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хөгжилтэй харилцан уялдаж байх ёстой. Одоо үед Хятад улс, ялангуяа Жилинь муж нь уламжлалт ХАА, газар тариалангийн хэлбэрээс орчин үеийн ХАА, газар тариалангийн хэлбэрийг туулж өнгөрүүлж, мөн уламжлалт экспортын аж үйлдвэрийн загвараас шинэ үеийн аж үйлдвэрийн загварт шилжиж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн ажиллах хүчний илүүдэл болон ой, уул уурхайн бүс нутаг дахь ажилчид ажилгүй болох зэрэг асуудал урган гарч ирж байна. 2002 онд мужийн хөдөө тосгоны ажиллах хүчний илүүдэл 2 сая гаруй, хотын ажилгүйдлийн хэмжээ ойролцоогоор 500 мянга хүрээд байна. Иймээс ажиллах хүч гаргах шаардлагад хүрч байгаа юм. Харин ОХУ, Монгол Улс ажиллах хүч дутагдах байдалтай тулгарч байгаа учир ажиллах хүчний хамтын ажиллагаа болон ой мод, уул уурхайн нөөц баялагийн тал дээр хамтран ажиллах нь бас хөгжлийн ирээдүйтэй юм.

### **Гурав. ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хөгжилт болон хамтран ажиллахад тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлууд**

ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны судалгаа эхлээд 10 гаруй жил болжээ. Ерөнхийлөн хэлэхэд, судалгаа урагштай, хөгжил хоцронгуй, хэлэх нь олон, хэрэгжих нь цөөн гэх мэт дутагдалтай асуудлууд байсаар байна. Иймэрхүү байдал үүсэх болсон шалтгаан нь эдрээтэй ярвигтай юм. Гэвч ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны туршлагаас харахад дараахи хэдэн асуудлыг зайлшгүй анхаарах шаардлагатай.

1. Аливаа хөгжилд амар хялбараар гарч ирэх боломж эсвэл эдийн засгийн гэнэтийн уналтыг хүлээх бус, харин тодорхой үйл явцын хуримтлал шаардагддаг. Жишээ нь, 90-ээд оны эхэн үед Түмэн голын ашиглалтын асуудалд Жилиний хүмүүс их найдлага тавьж хэдэн арван тэрбум хөрөнгө оруулалтыг дөрвөн зүг найман зовхисоос бууж ирэх юм шиг төсөөлж, Рашаан уулаас Түмэн гол хүртэл, зүүн талаараа Японы Шиншэ, баруун талаараа Оросын Байгаль нууртай холбох их төлөвлөгөөг боловсруулж байсан юм. Гэтэл одоогийн байдлаар бид

нар дөнгөж төмөр замаа Оросын эрэг хавийн Краскино боомттой холбоод байна. Иймд ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг бага багаар урагшлуулж, төслөө нэг нэгээр гүйцэтгэн хэрэгжүүлж, хүчин чадавхиа алхам алхамаар хуримтлуулах шаардлагатай байна.

2. Аливаа хамтын ажиллагааны амжилт нь харилцан ашигтай, хоёр талдаа үр дүнтэй байх хэрэгтэй.

Арилжаа худалдааны ашгийг хамтрагч талууд байнга хуваалцдаг ба тэр ашгийг олохын тулд заавал эрсдлийг даван туулдаг. Хятадын эртний агуу сэтгэгч Лаоз ямар нэг юм олж авахын тулд ямар нэг юмаа золиослодог гэж сургамжилсан. Орчин үеийн Хятад хүмүүс чи юу хийнэ, түүнийхээ үр шимийг хүртэх ёстой гэж ярьдаг. Хятадын машин үйлдвэрлэлийн корпорациар жишээ авья л даа. 80-иад оны эхэн үед Хятадын аж ахуйн нэгж, бизнесийн хүрээнийхэн Японд очин суралцдаг байсан. Японы машин аль хэдийн Хятадын зах зээлийг эзэлчихсэн байлаа. Тэр үед Хятадын хотуудын бүх гудамжинд “Хаана зам байна тэнд Тоёото” гэх Японы реклам дүүрэн байдаг байв. Гэвч Японы бизнесийн хүрээнийхэн үйл ажиллагаандаа маш болгоомжтой ханддаг байв. Харин эсрэгээр Германы Вольксваген групп нь Хятадын Чанчунь, Шанхай хотын 2 том машин үйлдвэрлэлийн компанитай хамтран ажиллах хэрэгтэйг ойлгуулсан юм. Одоо үед бол хаа сайгүй л “Ауди”, “Сантана” машин хөлөглөж байна. Үүний адил 90-ээд оны эхэн үед Хятад улсын бизнесийнхэн ОХУ-руу ихээр шуурч эхэлсэн. Гэвч зөвхөн ашиг орлогоо бодон, барааны чанар, арилжааны хэв маягаа бодолцоогүйгээс багагүй сөрөг үр дагавар үүсэн бий болсон юм. Энэхүү сөрөг үр дагавар одоо ч байсаар байна.

3. ЗХА-ийн улс орнуудын бодит байдлаас харахад ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд аж ахуйн нэгж болон төр засгийн уялдааг заавал уялдуулах хэрэгтэй.

Хэдийгээр ЗХА-ийн улс орнуудын байдал өөр хоорондоо харилцан адилгүй ч, төр засаг, засаг захиргааны эдийн засагт нөлөөлөх хамаарал болон саад болох хүчин зүйл нь барууны орнуудынхыг бодвол илүү юм. Энэ тал дээр сайн зүйл ч бий, саар зүйл ч бий. Харин бүс нутгийн хамтын ажиллагааны эхлэх үе шатнаас харахад төр засгийн нөлөө, дэмжлэгийн давуу тал нь илэрхий байдаг. “Хүчирхэг төр засагтай” аль ч газрын аж ахуйн нэгжүүд ихэвчлэн бие даасан байдал дутагдалтай байдаг. Хэрвээ төр засгийн дэмжлэг тусалцаа, хуулийн болон бодлогын хамгаалалт байхгүй бол гадаадын хөрөнгө оруулалт

хэрэгжих нь хүндрэлтэй байдаг. Төр засгийн эдийн засагт нөлөөлөх нөлөө нь эдийн засгийн хөгжил болон аж ахуйн нэгжийн бие даасан байдлын хэрээр аажмаар сулардаг байна. Тэгэхгүй бол зах зээлийн тогтворгүй, эмх замбараагүй байдлыг амархан үүсгэдэг. Энэ мэт хохирол нь төр засагт буглагдсан хүнд суртлаас багагүй байна.

4. ЗХА-ийн улс орнуудын соёлын ялгааг сайтар анхааран үзэх хэрэгтэй.

ЗХА-ийн улс орнууд түүхэндээ нягт холбоотой, соёлын хувьд харилцан бие биедээ нөлөөлж байсан. Гэвч соёлын ялгаа хадгалагдсаар байна. Одоо үеийн нийгэм бол мэдээллийн нийгэм. Эдийн засаг, соёл нь интеграцчлагдаж байна. Энэ нь нэг талдаа хүмүүсийн соёлын хэрэгцээ шаадлага физиологийн шаардлагаас илүү өсөж байгаа, нөгөө талдаа мэдээлэл нь соёлыг эдийн засгийн бараа бүтээгдэхүүн болгож байгаа явдал юм. Жишээ нь: Диск, шинжлэх ухаан, технологийн ололт бүтээлүүд гэх мэт. Үндэстэн дамнасан хамтын ажиллагаа нь өөрөө үндэстэн дамнасан соёлын харилцаа юм. Жилинь мужийнханы 20 жилийн тэртээгээс эхэлсэн олон улсын хамтын ажиллагааны туршлага, сургамжийг дүгнэхэд маш олон алдаа гаргасан ба үүний үндсэн шалтгаан нь соёлын ялгаатай холбоотой байдаг. Харилцагч орныхоо соёлыг мэддэггүй нь аливаа маргаан зөрчлийн үндэс болдог. Үндэстэн дамнасан хамтын ажиллагааны үндэс суурь харилцан бие биенээ ойлгох, итгэх юм. Харин ойлгох итгэхийн үндэс суурь бол тухайн соёлыг хүлээн зөвшөөрөх ойлгох явдал юм. Даяаршлын өнөө үед соёлын олон талт байдал нь эдийн засгийн хамтын ажиллагааны урьдач нөхцөл болдог.

Хятадын Жилинь муж эсвэл Хэйлунжян, Ляонин ч бай, аль эсвэл Япон, БНСУ, БНАСАУ, Монгол Улс, Орос ч бай, даяаршлын энэ эрин үед хамтын ажиллагаагаа өргөжүүлэн бэхжүүлэх аваас харилцан бие биедээ харилцан ашигтай юм. Бид нар ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжин цэцэглэнэ гэдэгт найдсаар байна.

*Хятад хэлнээс орчуулсан ОУХДС-ийн  
магистрант Б.Цэнгэлмаа*